



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 519

Улаанбаатар хот

“Бодь даатгал” ХХК-ийн эрх бүхий  
албан тушаалтныг томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 55.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Бодь даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар Бадарч овогтой Отгонбаярыг томилохыг зөвшөөрсүгэй.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгуулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг Б. Отгонбаярт үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000880